

Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээний хөтөлбөр

Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ (БОГУ) нь үнэлгээ хийлгэж байгаа улс орны байгаль орчны чиглэлээр олон улсын хэмжээнд өгсөн үүрэг амлалтаа биелүүлэх явцад байгаль орчин, эдийн засгийн зорилтуудтай уялдуулан гаргасан ахиц дэвшлийг хөндлөнгөөс үнэлэх ажил юм.

1991 оноос хойш эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага нь өөрийн гишүүн улс оронд зориулан БОГУ (EPR) хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Европын Байгаль орчны сайд нарын хоёрдугаар бага хурлаар (Люцерн, Швейцарь, 1993) НҮБ-ын Европын Эдийн засгийн комисс (ЕСЕ) нь сонирхол илэрхийлсэн орнуудын БОГУ-г хийж байх шийдвэр гаргасан.

Энэхүү хөтөлбөр нь дараах үндсэн зорилтуудтай, үүнд:

- Байгаль орчны хэрэгжилтийн талаар тодорхой зөвлөмж өгөх замаар байгаль орчны менежмент, гүйцэтгэлийг сайжруулахад туслах ;
- Улс хоорондын туршлага болон бодлогын талаар мэдээлэл солилцох ажлыг хөхиүлэн дэмжих;
- Байгаль орчны бодлогыг эдийн засгийн салбаруудын (ХАА, эрчим хүч, эрүүл мэндийн) бодлоготой уялдуулахад туслах;
- Олон нийтийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх ;
- Олон улсын хамтын нийгэмлэгтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- Холбогдох ТХЗ-д хүрэх, хэрэгжилтэд хяналт тавихад хувь нэмэр оруулах.

Энэхүү сайн дурын үндсэн дээр хийлгэж буй үнэлгээний ажлыг тухайн улс орны хүсэлтийн дагуу хийдэг. Олон улсын шинжээчдээс бүрдсэн үнэлгээний баг нь тухайн улсын үндэсний шинжээчид, иргэний нийгэм, олон улсын хамтын нийгэмлэгийн төлөөлөлтэй уулзаж, тайланд тусгахаар төлөвлөсөн асуудлын дагуу ярилцаж тодруулга авдаг.

Тухайн шатны БОГУ-ний ажлыг хийснээр урьд өмнө хийсэн үнэлгээний тайлангийн хугацаанаас хойш хийсэн

ажил, гарсан ахиц дэвшлийг харгалзан үнэлж, цаашид хэрхэн сайжруулах тухай зөвлөмжийг боловсруулдаг. ЭЗК-ын шинжээчдийн баг нь байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээг хийж гүйцэтгэдэг. Үнэлгээний тайланд тусгасан дүгнэлт, зөвлөмжийг НҮБЭЗК-ын Байгаль орчны бодлогын хороонд танилцуулан батлуулдаг.

Үндэсний хэмжээнд үнэлгээг хийх чадавх, чиг хандлага, бодлогын хүрээнд хийсэн амлалт, бүтэц зохион байгуулалтын зохицуулалт гэх суурь нөхцөлүүдийг **1 дүгээр шатны БОГУ**-ний ажлаар тогтоодог.

1996 оноос хойш ЭЗК-ын бүсийн дараах улс орнууд 1 дахь БОГУ-г хийлгэсэн, үүнд: Албани, Армени, Азербайжан, Босни Герцеговина, Хорват, Эстони, Гүрж, Казахстан, Киргиз, Латви, Литва, Молдав, Румын, Словени, Тажикистан, Хойд Македон, Туркменистан (2012 онд 3-р шатны БОГУ-ийн аргачлалын дагуу), Украин, Узбекистан, Югослав багтаж байна.

Хоёр дахь шатны БОГУ нь эхний үнэлгээнээс хойш гарсан ахиц дэвшлийг үнэлж, илүү хариуцлагатай байх зөвлөмжийг өгдөг. Тус тайланд Байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, байгаль орчны асуудлыг эдийн засгийн салбартай уялдуулах, тогтвортой хөгжлийг дэмжих талаар онцлон тусгадаг.

2000 оноос хойш ЭЗК нь Албани, Азербайжан, Беларусь, Босни Герцеговина, Болгар, Хорват, Эстони, Гүрж, Казахстан, Киргизстан, Монтенегро, Бүгд Найрамдах Молдав, Румын, Серби, Тажикистан, Хойд Македон, Украин болон Узбекистан зэрэг улс орнуудын хоёр дахь шатны БОГУ-г хийсэн.

Европын Байгаль орчны сайд нарын 7 дугаар бага хурал дээр (Астана, Казахстан, 2011) ЭЗК-ын БОГ-ийн хөтөлбөрийг дэмжиж байгаагаа сайд нар дахин илэрхийлсэн. Иймд гурав дахь шатны үнэлгээг хийх шийдвэр гарсан. Европын Байгаль орчны Сайд нарын 8 дахь бага хурал (Батуми, Гүрж, 2016)-аар сайд нар **Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, хяналтыг** дэмжихэд БОГУ-ний үүргийг онцлон тэмдэглэсэн .

Гурав дахь шатны БОГУ нь ногоон эдийн засгийн нөхцөл байдлын хүрээнд байгаль орчны засаглалын асуудлыг санхүүжилтийн асуудалтай хамт авч үзэхийг сацуу тухайн улсын гадаад хамтын ажиллагаа, болон тэргүүлэх салбаруудад байгаль орчны асуудлыг тусгах асуудлаар түлхүү чиглэн үнэлгээг өгдөг.

2017 оноос хойш хийж буй БОГУ-ний ажлууд нь 2030 он хүртэл хэрэгжүүлэх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тусгаж байна.

2012 оноос ЭЗК нь Албани, Армени, Азербайжан, Беларусь, Босни Герцеговина, Болгар, Гүрж, Казахстан, Киргиз, Монтенегро, Хойд Македон, Бүгд Найрамдах Молдав, Румын, Серби, Тажикистан, Узбекистан зэрэг улсуудын гурав дахь шатны БОГУ-г хийсэн.

Европын Байгаль орчны сайд нарын есдүгээр бага хурал дээр (Никосиа, Кипр, 2022) сайд нар БОГУ-ний **4 дэх шатны үнэлгээг баталж**, улс орнуудыг байгаль орчны үнэлгээг үргэлжлүүлэн хийлгэж, БОГУ-ний зөвлөмжийг хэрэгжүүлэх замын зураглалыг боловсруулахыг уриалсан.

Дөрөв дэх шатны БОГУ нь гурав дахь шатны БОГУ- тай төстэй ч улс орны хэрэгцээ шаардлагаас хамааран тойрогт эдийн засгийг сайжруулах, байгаль орчны бодлогод жөндөрийн асуудлыг тусгах, байгаль орчны хүний эрхийн асуудал, харилцаа уялдаа холбоотой хандлагыг харгалзан санал дэвшүүлдэг байна. 2023-2024 онуудад Тажикистан, Монтенегро зэрэг улсын дөрөв дэх шатны БОГУ-г хийж байна.

БОГУ-ний ажлын үр ашигтай, үр дүнтэй аргачлалыг ЭЗК-ын бүсээс гадуур орших орнууд өндрөөр үнэлж, энэхүү аргачлал болон ноу-хауг НҮБ-ын бусад бүс нутгийн комисстой хуваалцах хүсэлтийг гаргаад байна. ЭЗК-ын бүсэд хамаардаггүй ч БОГУ-г ЭЗК-ын аргачлалаар хийлгэсэн анхны орон бол Марокко, Энэхүү үнэлгээг ЭЗК нь НҮБ-ын Африкийн Эдийн засгийн Комисс (ЕСА)-той хамтран хийсэн. Монгол Улсын 1 дахь шатны БОГУ-г НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисстой хамтран хийсэн. Марокко улсын хоёр дахь тайланг Мавритани улсын үнэлгээний ажлын хамт Африкийн ЭЗК-той хамт үнэллээ.



Монгол улсын Байгаль орчны гүйцэтгэлийн 2 дугаар тайланг боловсруулах шинжээчдийн баг Улаанбаатар хотод

2024 оны 9-р сарын 16-25-ны хооронд ажиллана.

Хамрах хугацаа: 2017–2023 он

1. Байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжлийн тухай хууль эрх зүйн орчин, бодлого, институцийн тогтолцоо (Ник Бонвоисин, НҮБ-ын ЕЭЗК, nicholas.bonvoisin@un.org)
2. Зохицуулалт ба нийцлийн (дагаж мөрдөх баталгааны) механизмууд (Крис Дайкинс, НҮБ-ын ЕЭЗК, chris.dijkens@gmail.com)
3. Эдийн засгийг ногоон болгох, байгаль орчныг хамгаалах санхүүжилт (Olimpija Hristova Zaevska, НҮБ-ын ЕЭЗК, olimpija@elsonsolutions.com)
4. Байгаль орчны хяналт ба мэдээлэл (Марай Шаустра, НҮБ-ын ЕЭЗК, marije.schouwstra@minienw.nl)
5. Мэдээллийн хүртээмж, олон нийтийн оролцоо, шударга байдлын хүртээмж (Елизавета Алексеева, НҮБ-ын ЕЭЗК, e.aleksyeyeva@gmail.com)
6. Тогтвортой хөгжлийн боловсрол (Анжела Сочирка, НҮБ-ын ЕЭЗК, angela.sochirca@un.org)
7. Уур амьсгал өөрчлөлт (Теодора Гринкаровска, НҮБ-ын ЕЭЗК, dori.moepgovmk@gmail.com)
8. Олон улсын гэрээ, үүрэг амлалтын хэрэгжилт (Батыр Хаджиев, НҮБ-ын ЕЭЗК, batyr.khadzhiev@un.org)
9. Агаарын хамгаалалт (Оливера Кужунзик, НҮБ-ын ЕЭЗК, ohoo29@gmail.com)
10. Усны менежмент (Анабела Ребело, Португал улс, anabela.rebelo@apambiente.pt)
11. Хог хаягдал, химийн бодисын менежмент (Мажа Колович -Даул, НҮБ-ын ЕЭЗК, maja.daul@gmail.com)
12. Биологийн олон янз байдал ба тусгай хамгаалалттай газар нутаг (Збигнев Ниевиадомски, НҮБ-ын ЕЭЗК, zbig-niew@wp.pl)
13. Ойн тогтвортой менежмент (Эндрю Инглис, НҮБ-ын ЕЭЗК, asinglis@gmail.com)
14. Газрын тогтвортой менежмент (Элизабет Клемент Арнолд, НҮБ-ын ЕЭЗК, e.clement@ik.me)
15. Зудын менежмент (НҮББОХ) З.Батжаргал (z_batjargal@yahoo.com)
16. Байгалийн болон технологийн/антропоген аюулын эрсдэлийн удирдлага (НҮБ-ын ЕЭЗК, karin.fueri@un.org)
17. Эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, байгаль орчин (Силви Эймард, Франц улс, sylvie.eymard@gmail.com)

БОГУ-тэй холбоотой ТХЗ-уудыг бүлэг тус бүрд тусгах болно

Хүйсийн болон байгаль орчны эрхийн асуудлуудыг бүлэг тус бүрд авч үзнэ.

Анхны БОГУ-ний зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох бүлэгт тусгах болно

Хавсралтууд

1. БОГУ -ний зөвлөмжийн хэрэгжилт
2. 1 дахь БОГУ- д тусгасан ТХ зорилтуудын онцлог
3. ОУ-ын БО-ны гэрээ хэлэлцээр дах оролцоо
4. Байгаль орчны хууль тогтоомжийн жагсаалт
5. Эх сурвалжууд

**НҮБ-ын
Европын эдийн засгийн комисс (UNECE)**
Байгаль орчны хэлтэс
СН-1211 Женев 10, Швейцарь
НҮБын ордон

Антуан Нунес
Хөтөлбөрийн менежер
Утас : + 41 79 277 5243
antoine.nunes@un.org

Елена Сантер
Үндсэн зохицуулагч
elena.santer@un.org

Даваагийн Нарантуяа
Дотоод Логистик зохицуулагч
99110474
dnarantuyad@gmail.com


БОГУ-ний тайланг доорх QR -аас татаж үзэх боломжтой
www.unece.org/env/epr/



 info.epr@un.org

НҮБ-ын ЕВРОПЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОМИСС

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ



МОНГОЛ УЛС

2 ДУГААР ТАЙЛАН



UNITED NATIONS